



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 11 өдөр

Дугаар 1/62

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8 дах заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Газрын харилцаа геодези, зурагзүйн газрын даргын 2015 оны А/105 дугаар "Журам, заавар батлах тухай" тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд бэлчээрийн төлөв байдал чанарын өөрчлөлтийн явцыг хянах, урьдчилан сэргийлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх, мэдээллийн сан үүсгэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Цэнд-Аюуш (Газрын даамал)

Гишүүд: Б.Довуучий (Багийн засаг дарга)

Б.Баттогтох (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

2. Фотомониторингийн ажлыг 08 дугаар сарын 12 ны өдрийн дотор багтаан зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэх, тайлан мэдээ боловсруулах ажлыг гүйцэтгэж, үр дүнг сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тогтоосон цэгт ажиллахад шаардлагатай шатахууны зардлыг Засаг даргын Тамгын газрын шатахууны зардлаас шийдвэрлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Нарантунгалаг)-т даалгасугай

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Л.ЗОЛЖАРГАЛ